

ДОТООДЫН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ



Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- 11-р сард улсын инфляц 8.2%-д хүрлээ
- ТОП-20 компанийн дундаж үнэ ашгийн харьцаа 5.56 байгаа буюу багаар үнэлэгдсэн хэвээр байна.
- Short selling буюу үнэт цаас зээлдүүлэх зохицуулалтыг баталлаа

МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	0.91%	0.92%	25.47%
MSE A	0.86%	-0.01%	20.27%
MSE B	-0.45%	-0.97%	34.89%

2025/12/08 – 2025/12/12

Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
APU	1,395,428,937.39
KHAN	1,051,390,961.00
MNDL	1,000,581,888.06
TGI	568,388,045.22
OLL	372,344,848.75

2025/12/08 – 2025/12/12

Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
OLL	63.25	66.89%
HBZ	2,731.00	14.99%
ADU	300.00	14.71%
ITLS	73.99	8.81%
SEND	151.95	6.56%

2025/12/08 – 2025/12/12

2025 он 12-р сарын 15

Зах зээлийн
үнэлгээ тэрбум ₮

13,374

ТОП-20 индекс

52,121

MSE A

19,778

MSE B

14,663



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

5.6%

2025 - III улирал

Инфляц

8.2%

2025-11 сар

ГВУН(сая\$)

6,014.20

2025-11 сар

Бодлогын
хүү

12.0%

ЗГ-ын бондын
өгөөж

6.6%

USD/MNT

3,544.81

2025-12-14


Эдийн засгийн мэдээлэл

11-Р САРЫН ИНФЛЯЦ 8.2%-Д ХҮРЛЭЭ

2025 оны 11 дүгээр сард хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 8.2 хувиар өссөн нь инфляцын дарамт өргөн хүрээнд, тогтворжихоосоо илүүтэй хэвээр байгааг харуулж байна. Үнийн өсөлтөд хүнсний бараа, ундаа, усны бүлэг 12.0 хувиар өссөн нь гол нөлөө үзүүлсэн бөгөөд ялангуяа согтууруулах бус ундааны үнэ 10.2 хувиар нэмэгдсэн нь өрхийн өдөр тутмын зардалд шууд дарамт учруулж байна. Мөн боловсролын үйлчилгээ 12.8 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 10.9 хувь-иар өссөн нь үйлчилгээний салбар дахь зардлын инфляц үргэлжилж буйг илтгэнэ.

Сарын дүнгээр авч үзвэл, 2025 оны 11 дүгээр сард инфляц өмнөх сараас 0.6 хувиар нэмэгдсэн бөгөөд энэ өсөлт улирлын болон эрэлтийн хүчин зүйлээс гадна зардлын суурь дарамт бүрэн арилаагүй байгааг харуулж байна. Тухайлбал, хувцас, бөс бараа, гутлын үнэ 1.9 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ мөн 1.9 хувь, бусад бараа, үйлчилгээ 1.5 хувиар тус тус өссөн нь үнийн өсөлт ганц хүнсээр хязгаарлагдахгүй, хэрэглээний олон ангилалд тархсаныг нотолж байна.

График 1. Хэрэглээний үнийн индекс



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ҮНЭТ ЦААС ЗЭЭЛДҮҮЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫГ СЗХ-ООС БАТАЛЛАА

Санхүүгийн Зохицуулах Хорооны 20 дугаар хуралдаанаар “Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээ үзүүлэх тухай журам”-ыг баталснаар Монгол Улсад үнэт цаас зээлдүүлэх шинэ төрлийн үйлчилгээ нэвтрэх эрх зүйн орчин бүрдлээ. Энэ нь 2024 оны 5 сард Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд хэрэгжих боломжтой болсон юм.

Журам нь Олон улсын үнэт цаас зээлдүүлэх холбоо (ISLA)-ны зарчим болон олон улсын зохицуулалтын жишигт тулгуурлан боловсруулагдсан бөгөөд үнэт цаас зээлэх, зээлдүүлэхэд тавигдах шаардлага, зээлдүүлэх боломжтой үнэт цаас, гэрээний нөхцөл, барьцаа хөрөнгийн удирдлага, оролцогчдын эрх, үүрэг, мэдээлэл, тайлагналын зохицуулалтыг нарийвчлан тусгасан байна.

Журам хэрэгжиж эхэлснээр мэргэжлийн хөрөнгө оруулагчид эзэмшиж буй үнэт цаасаа зээлдүүлэх замаар нэмэлт орлого олох, хөрөнгө оруулалтын багцаа илүү үр ашигтай удирдах боломж бүрдэнэ. Үүний зэрэгцээ зах зээлийн хөрвөх чадвар, арилжааны идэвх нэмэгдэж, Монголын хөрөнгийн зах зээл олон улсын жишигт ойртон, өрсөлдөх чадвар болон гадаадын хөрөнгө оруулалт өсөхөд эерэг нөлөө үзүүлэхээр байна.



Зах зээлийн мэдээлэл

2025 ОНЫ ДОТООДЫН ЗАХ ЗЭЭЛИЙГ ДҮГНЭХ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

- ₮13.3 их наяд – Өнөөдрийн байдлаар Монголын хувьцааны зах зээлийн нийт үнэлгээ
- ТОП-20 компанийн цэвэр ашиг 23 орчим хувиар буурав: ТОП20-ын цэвэр ашиг 2024 оны эхний хагаст ₮1.3 их наяд байсан бол 2025 оны эхний хагаст ₮1.0 их наяд болж буурсан билээ.
- ТОП-20 индексийн дундаж үнэ ашгийн харьцаа 5.56 бол банкнуудын P/E 4.43 байна. ТОП-20 индексийн дундаж P/E, банкны салбарын P/E түүхэн доод түвшинд ирсэн бөгөөд үнэлгээ бага байгааг илтгэж байна.
- ₮1.1 их наяд – 2025 онд тараасан ногдол ашиг ба үүний ₮600 тэрбум буюу 55 орчим хувт нь банкны салбараас тараав.
- ТОП-20 индексийн улирлын хэв маяг нь эхний хагаст сул, сүүлийн хагаст идэвхждэг
- Монголбанкны бодлогын хүү 2026 оны эхний хагас дуустал 12%, инфляц 9%-иас доош буурахгүй тул бондын хөрөнгө оруулалт илүү ашигтай.


Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2025 оны 12 дугаар сарын 10–11-нд хуралдаж, бодлогын хүүг 12 хувь дээр хэвээр хадгалах шийдвэр гаргалаа. Энэ нь инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшинд тогтворжуулах, эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах зорилготой юм.

Тэтгэврийн зээлтэй холбоотой гол шийдвэрүүд

- Тэтгэвэр, тэтгэмжийн орлого барьцаалсан зээлийн дүнтэй тэнцэх эх үүсвэрийг банкуудын заавал байлгах нөөцөөс хасаж тооцно.
- Тэтгэврийн зээлийн нийт хугацааг 36 сараас хэтрэхгүйгээр нэг удаа сунгаж, сарын төлбөрийг бууруулсан тохиолдолд уг зээлийг бүтэц өөрчлөгдсөн зээлд тооцохгүй.
- Тэтгэврийн зээлийн эрсдэлийн жинг 150%-иас 100% болгон бууруулна.

ТОП-20 ИНДЕКС ОНЫ СҮҮЛИЙН ХАГАСТ ӨСӨЛТТЭЙ БАЙНА


График 3. ТОП-20 индексийн ханшийн график



ТОП-20 индекс 2025 оны эхний улиралд түүхэн дээд ханш болох 54,018-д хүрсэн билээ. Өнөөдрийн байдлаар 51,651 байгаа бөгөөд оройн цэгээсээ 4.4 хувиар ойролцоогоор унасан дүр зурагтай байна.

ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.

ВАЛЮТЫН ХАНШИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Хэрэв нүүрсний үнэ 10%-иар буурч экспортын орлого 800 сая ам.доллараар багасна гэж үзвэл: 2026 онд инфляц 0.7 нэгж хувиар нэмэгдэхтэй уялдан төгрөгийн ханш ам.долларын эсрэг 3-5% орчим сулрах магадлалтай.

График 1. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш

